

ОНЦЛОХ ДЭД ТӨСЛҮҮДЭЭС:



Төрийн цахим худалдан авах ажиллагааны системийн шинэчлэл, хиймэл оюун ухааны модуль хөгжүүлэлт

Төрийн бүх шатанд худалдан авах үйл ажиллагааг бүрэн цахимжуулж, ил тод байдлыг хангах, мэдээллийн үнэн зөвийг сайжруулах зорилгоор Төрийн цахим худалдан авах ажиллагааны системийг шинэчлэн, хиймэл оюун ухаанд суурилсан модулиудыг хөгжүүлж нэвтрүүлэхээр төлөвлөж байна.

Одоогийн ашиглагдаж буй системийн хувьд худалдан авах ажиллагаатай холбоотой мэдээллийг цахимжуулж, нийтлэх болон

Үндэсний хэмжээний кибер халдлагад хариу үзүүлэх чадавхыг дээшлүүлэх, кибер аюулгүй байдлын зөвлөлийн ажлын албаны үйл ажиллагаа, цахим шилжилтийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ. Монгол Улсад долоо хоногт дунджаар 140 гаруй мянган сэжигтэй хандалт бүртгэгдэж байна. Үүний дийлэнх хувийг хортой код, системд хайлт хийх, нууц үг хулгайлах, сервер эзлэх, системийн цоорхой ашиглах төрлийн халдлагууд эзэлж байна.



Улсын бүртгэлийн цахим мэдээллийн хадгалалт, хамгаалалт, нууцлал, аюулгүй байдлыг сайжруулах дэд бүтцийг бий болгох

Төслийн хүрээнд улсын бүртгэлийн цахим үйлчилгээний тасралтгүй, хэвийн ажиллах нөхцлийг бүрдүүлэх, цахим аюулгүй байдал, найдвартай үйл ажиллагааны чадавхыг бэхжүүлнэ.

гадаад хэрэглээнд өгөгдлийг бүрэн, үр дүнтэй ашиглах боломжийг хязгаарласан хэвээр байна. Системийн шинэчлэл хийгдсэнээр төрийн худалдан авах ажиллагааны процессыг хэрэглэгчдэд илүү ойлгомжтой, хялбар хүргэхийн зэрэгцээ мэдээллийн урсгал сайжирч, нарийвчлал нэмэгдэн, дата цуглуулалт, тайлагнал, боловсруулалтын чадавх улам боловсронгуй болно. Мөн техникийн шинэ чиг хандлага, шаардлагад нийцүүлэн суурин болон гар утасны төхөөрөмжид бүрэн таарсан, хүртээмжтэй ашиглалтын орчин бүрдэх юм.

Кибер халдлага, зөрчилтэй тэмцэх нийтийн төвд тоног төхөөрөмж нийлүүлэх



Кибер аюулгүй байдлын зөвлөлийн ажлын алба нь 2023 онд байгуулагдсан бөгөөд үндэсний хэмжээний кибер халдлагад хариу үзүүлэх төлөвлөгөөний хэрэгжилтийг зохион байгуулах үүрэгтэйгээр ажилладаг. Төслийн хүрээнд үндэсний хэмжээний кибер халдлага, зөрчилд хариу үзүүлэхэд шаардлагатай техник, программ хангамжийн дэмжлэг үзүүлснээр ажиллах орчин нөхцөл, дэд бүтэц, чадамж сайжрах юм.

Чадавхи сайжирснаар аливаа гамшиг, эрсдэлийн үед төрийн цахим үйлчилгээ хэвийн ажиллах нөхцөл бүрдэх, дүн шинжилгээ, тайлагналтын үйл ажиллагааг боловсронгуй болгох, цахим орчин дахь аюулгүй байдлыг хангах зэрэг ач холбогдолтой.

ДЭЛХИЙН БАНКНЫ АЖЛЫН АЙЛЧЛАЛ АМЖИЛТТАЙ БОЛЖ ӨНДӨРЛӨЛӨӨ



Дэлхийн Банкны Зүүн Ази, Номхон далайн бүсийн Дижитал салбар хариуцсан менежер Жэймс Нойманаар ахлуулсан баг 11-р сарын 17-20-ны өдрүүдэд Монгол Улсад ажиллаж, “Ухаалаг засаг 2” төслийн хэрэгжилт болон цаашдын төлөвлөгөөний талаар холбогдох байгууллагуудтай уулзалт хийлээ. Айлчлалын багийг Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд болон төслийн үр шим хүртэгч байгууллагууд хүлээн авч хамтын ажиллагааны өргөн хүрээний хэлэлцүүлэг өрнүүлээ.

“УХААЛАГ ЗАСАГ-2” ТӨСЛИЙН УДИРДАХ ХОРООНЫ ХУРАЛ БОЛЖ ӨНГӨЛӨӨ

Дэлхийн Банкны дэмжлэгтэйгээр Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны хэрэгжүүлж буй “Ухаалаг Засаг-2” төслийн Удирдах хорооны хурал 11 сарын 14-ний өдөр хуралдлаа. Хурлаар төслийн дэд төслүүдийн хэрэгжилтийн явц, 2025 оны Худалдан авах ажиллагааны болон зарцуулалт, үйл ажиллагааны төлөвлөгөөг шинэчлэн хэлэлцэж баталлаа.

ТЕНДЕРИЙН УРИЛГА

MN-MDDC-2.1.2.2-2-EGP-RFP

“Ухаалаг Засаг-2” төслийн хүрээнд “Төрийн цахим худалдан авах ажиллагааны системийн шинэчлэл, хиймэл оюун ухааны модуль хөгжүүлэлт”-ийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах олон улсын нээлттэй тендер шалгаруулалтыг зарлагдлаа.

Дэлгэрэнгүйг: www.smart.gov.mn



ДЭЛХИЙН БАНКНЫ БАРИМТ БИЧИГ:
Байгаль орчин, нийгмийн стандарт

“Ухаалаг засаг 2” төслийн Төслийн нэгж нь төслийн гүйцэтгэл, ялангуяа байгаль орчин ба нийгмийн нөлөөлөл, цаашлаад төслийн үйл ажиллагаатай холбоотой нөлөөлөлд өртсөн хүмүүсийн санал, гомдлыг хүлээн авах, бүртгэх эдгээрт хариу өгөх, зохих арга хэмжээ авахад дэмжлэг үзүүлэх механизмыг хэрэгжүүлэн ажилладаг. Энэ хүрээнд дараах сувгуудаар өргөдөл, гомдол, санал хүсэлтийг хүлээн авч ажиллаж байна.

1 → 2 → 3 → 4 → **ӨРГӨДӨЛ, САНАЛ ГОМДОЛ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ҮЕ ШАТУУД:**



www.smart.gov.mn



Ухаалаг засаг-2 төсөл/Smart Government-2 Project Mongolia/



Ухаалаг Засаг-2 Төсөл



Smart Gov II Project_Ухаалаг Засаг-2 Төсөл



Ухаалаг Засаг-2 төсөл/Smart Government II Project/@smartgovll



info@smart.gov.mn



+976-51-261068